



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНЭ ЭРИН ЛАБОРАТОРИ СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/43/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Ж.Энхтуяа
Утас: 261628 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :Баян ташаагийн эх Аудит ХХК
Захирал: Т.Хоролсүрэн
Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЭ ЭРИН ЛАБОРАТОРИ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.АМАРТҮВШИН ТАНАА

2020.02.24 № 07/320
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэ эрин лаборатори сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шинэ эрин лаборатори сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	101,723,963.64	478,387,752.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
33	Авлага	-	21,000.00
335	Бусад авлага	-	21,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	21,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	101,723,963.64	47,366,752.40
351	Түүхий эд материал	66,160,962.64	17,201,333,74
35110	Тусгай зориулалтын материал	66,160,962.64	17,201,333,74
354	Хангамжийн материал	35,563,001.00	30,165,418.66
35410	Бичиг хэргийн материал	7,174,423.00	3,062,745.00
35420	Аж ахуйн материал	22,065,660.00	22,062,601.00
35440	Түлш шатах тослох материал	987,480.00	992,720.66
35470	Бусад хангамжийн материал	5,335,438.00	4,047,352.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,906,554,059.82	3,855,083,212.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,906,554,059.82	3,855,083,212.74
392	Биет хөрөнгө	3,892,335,023.23	3,835,633,847.99
39201	Барилга, байгууламж	3,750,560,295.00	3,750,560,295.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(133,948,582.08)	(200,922,873.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(9,999,999.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компютер)	88,461,917.79	178,561,288.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,419,451.06)	(75,808,778.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	417,929,719.86	428,291,638.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(280,851,127.87)	(334,486,364.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,744,680.00	4,744,680.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(327,219.36)	(490,829.04)
39217	Номын фонд	75,184,790.95	75,184,790.95
393	Биет бус хөрөнгө	14,219,036.59	19,449,364.75
39301	Програм хангамж	23,326,829.80	33,226,829.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,107,793.21)	(13,777,465.05)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ҮР ДҮН	4,008,278,023.46	3,902,470,956.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,008,278,023.46	3,902,470,956.14
51	Засгийн газрын хувь оролцоо	4,008,278,023.46	3,902,470,956.14
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	3,132,187,517.32	3,132,187,517.32
51101	Өмч: - Төрийн өмч	3,132,187,517.32	3,132,187,517.32
512	Хуримтлагдсан үр дүн	(1,008,309,303.35)	(1,114,116,361.67)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,008,309,303.35)	(1,008,309,303.35)

51220	Тайлант үеийн үр дүн		(105,807,058.32)
	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,884,399,809.49	1,884,399,809.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,008,278,023.46	3,902,470,956.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН	1,299,959,932.30	1,529,121,389.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,142,132.30	95,090,189.00
120	Нийтлэг татварын бус орлого	83,142,132.30	95,090,189.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	83,142,132.30	95,090,189.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	16,775,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	83,142,132.30	78,314,289.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮУИЛТИЙН ОРЛОГО	1,216,817,800.00	1,434,031,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,190,617,800.00	1,433,031,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,190,617,800.00	1,433,031,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,200,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн зах		1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,200,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,291,044,552.07	1,583,489,229.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,291,044,552.07	1,583,489,229.92
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,253,899,253.95	1,453,579,157.95
210101	Цалингийн зардал	906,199,026.36	951,015,552.68
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,632,411.53	125,510,307.00
210304	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,196,627.23	36,249,100.00
210401	Бичиг хэргийн зардал	4,552,035.00	8,580,712.00
210402	Тээвэр, шатахууны зардал	1,512,520.00	2,467,294.50
210403	Шуудан, холбооны зардал	8,115,302.00	17,816,514.84
210404	Ном хэвлэлийн зардал	197,495.00	72,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,126,702.00	8,915,656.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	731,000.00	899,000.00
210604	Урсгал засвар	10,789,480.00	3,826,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	25,907,926.00	109,576,510.35
210802	Аудит баталгаажуулах зардал	2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татварын зардал	131,900.00	131,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	54,800.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал	867,900.00	2,600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,314,148.19	21,030,374.50

Шинэ эрин лаборатори сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	121,594,780.64	161,832,136.08
213	Урсгал шилжүүлэг	37,145,298.12	129,910,071.97
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	656,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,325,298.12	129,254,071.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	8,915,380.23	(54,367,840.92)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	51,439,217.40
145001	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	51,439,217.40
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	(51,439,217.40)
6	НИЙТ ҮР ДҮН	8,915,380.23	(105,807,058.32)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	(1,017,224,683.58)	3,999,362,643.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэх үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	(1,017,224,683.58)	3,999,362,643.23
Тайлант үеийн үр дүн	-	-	8,915,380.23	8,915,380.23
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	(1,008,309,303.35)	4,008,278,023.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэх үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	(1,008,309,303.35)	4,008,278,023.46
Тайлант үеийн үр дүн	-	-	(105,807,058.32)	(105,807,058.32)
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	(1,114,116,361.67)	3,902,470,965.14

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,216,817,800.00	1,450,807,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		16,775,900.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		16,775,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	16,775,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,190,617,800.00	1,434,031,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,190,617,800.00	1,433,031,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,190,617,800.00	1,433,031,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,200,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн зах		1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,200,000.00	
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,202,957,800.00	1,418,760,100.00
21	Бараа ажил, үйлчилгээний зардал	1,165,812,501.88	1,288,850,028.03
210101	Үндсэн цалингийн зардал	906,199,026.36	951,015,552.68
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,904,848.02	125,531,307.00
210304	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,142,828.50	36,249,100.00
210401	Бичиг хэргийн зардал	8,779,220.00	2,237,229.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	2,472,535.16
210403	Шуудан холбооны зардал	8,115,302.00	17,816,514.84
210404	Ном, хэвлэлийн зардал	197,495.00	217,100.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардал	11,643,207.00	5,367,721.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	771,000.00	769,000.00
210604	Урсгал зардал	11,087,980.00	970,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,907,926.00	109,576,510.35
210802	Аудит баталгаажуулах зардал	2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татварын зардал	131,900.00	131,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	54,800.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал	867,900.00	2,600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,533,869.00	30,840,558.00
213	Урсгал шилжүүлэг	37,145,298.12	129,910,071.97
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	656,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,325,298.12	129,254,071.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	13,860,000.00	32,047,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	13,860,000.00	32,047,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан	13,860,000.00	32,047,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(13,860,000.00)	(32,047,000.00)

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,438,031,200.00	1,332,328,928.03	105,702,271.97	91,9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,438,031,200.00	1,320,553,028.03	105,702,271.97	91,9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,437,375,200.00	1,319,897,028.03	117,478,171.97	91,9%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	951,064,100.00	951,015,552.68	48,547.32	100%
210101	Үндсэн цалин	495,822,700.00	495,822,700.00	-	100%
210102	Нэмэгдэл	328,430,600.00	327,776,932.60	653,667.40	99.8%
210103	Унаа, хоол бусад нөхөн олговор	40,810,000.00	41,415,120.08	(605,120.08)	101.5%
210104	Урамшуулал	86,000,800.00	86,000,800.00	-	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,393,600.00	125,531,307.00	2,862,293.00	97,8%
210201	Тэтгэвэрийн даатгал	90,351,100.00	87,466,234.52	2,884,865.48	96.8%
210202	Тэтгэмжийн даатгал	9,510,600.00	9,691,684.82	(181,084.82)	101.9%
210203	ҮОМШӨ-ий даатгал	7,608,500.00	7,652,547.98	(44,047.98)	100.6%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,902,100.00	1,829,308.36	72,791.64	96.2%
210205	Эрүүл мэндийн даатгал	19,021,300.00	18,891,531.32	129,768.68	99.3%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,249,100.00	36,249,100.00	4,000,000.00	90.1%
210301	Гэрэл цахилгаан	16,158,000.00	17,763,399.54	(1,605,399.54)	100.9%
210302	Түлш, халаалт	21,181,400.00	15,576,000.46	5,605,399.54	73.5%
210303	Цэвэр, бохир ус	2,909,700	2,909,700.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	28,111,100.00	28,111,100.00	-	100%
210401	Бичиг хэрэг	3,396,900.00	2,237,229.00	1,159,671.00	65.9%
210402	Тээвэр, шатахуун	3,588,400.00	2,472,535.16	1,115,864.84	68.9%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,480,000.00	17,816,514.84	(336,514.84)	101.9%
210404	Ном, хэвлэл	217,100.00	217,100.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,428,700.00	5,367,721.00	(1,939,021.00)	156.6%
2105	Норматив зардал	771,000.00	769,000.00	2,000.00	99.7%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	771,000.00	769,000.00	2,000.00	99.7%

Шинэ эрин лаборатори сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	130,982,200.00	20,917,200.00	110,065,000.00	16.0%
210603	Багаж, техник, хэрэгсэл	130,000,000.00	19,947,000.00	110,053,000.00	15.3%
210604	Урсгал засвар	982,200.00	970,200.00	12,000.00	98.8%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,756,100.00	124,263,210.35	492,889.65	99.6%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,069,400.00	109,576,510.35	492,889.65	99.6%
210802	Аудит баталгаажуулах зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татварын зардал				
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,800.00	54,800.00	-	100%
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал	12,500,000.00	12,500,000.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,048,000.00	33,040,558.00	7,442.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,048,000.00	33,040,558.00	7,442.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	656,000.00	656,000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	656,000.00	656,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	656,000.00	656,000.00	-	100%
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,438,031,200.00	1,332,328,928.03	105,702,271.97	92.6%
131	Улсын төсвөөс санхүүжих	1,433,031,200.00	1,315,553,028.03	117,478,171.97	91.8%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,433,031,200.00	1,315,553,028.03	117,478,171.97	91.8%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	16,775,900.00	(11,775,900.00)	335.5%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	16,775,900.00	(11,775,900.00)	335.5
3	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
4	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЭЛ				
61	Байгууллагын тоо	1	1		100
62	Ажиллагсдын тоо	53	53		100
62001	Удирдах ажилтан	1	1		100
62002	Гүйцэтгэх ажилтан	52	52		100

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинэ эрин лаборатори сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Баян ташаагийн эх Аудит ХХК-ийн захирал Т.Хоролсүрэн, аудиторын туслах Д.Балжирдорж нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг менежер Ч.Чимгээ хэрэгжүүлсэн.

Шинэ эрин лаборатори сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 02/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ерөнхий боловсролын Шинэ эрин лаборатори сургууль нь олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, боловсролтой монгол хүүхдийг төлөвшүүлнэ гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Монгол улсын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх
- Олон улсын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх
- Судалгаа шинжилгээ, туршилтын ажил хийх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг судалж үзэхэд тус байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын асуудлын хүрээний байгууллагуудад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тайлант онд сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэ эрин лаборатори сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн 1,299,044.50 мянган төгрөгөөс 1.0 хувь 12,990.44 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шинэ эрин лаборатори сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105,807.1 мянган төгрөгөөр буюу 1.02 хувиар буурсан материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материал данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	21,000.00	21,000.00
Бараа материал	101,723,963.64	47,366,752.40	(54,357,211.40)
Үндсэн хөрөнгө	3,906,554,059.82	3,855,083,212.74	(51,470,847.08)
Нийт хөрөнгө	4,008,278,023.46	3,902,470,965.14	(105,807,058.32)
Засгийн газрын оролцоо/Эздийн өмч/	3,132,187,517.32	3,132,187,517.32	0.00
Хуримтлагдсан үр дүн	(1,008,309,303.35)	(1,114,116,361.67)	(105,807,058.32)
Хөрөнгийн дахин үнэлгээний дүн	1,884,399,809.49	1,884,399,809.49	0.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,008,278,023.46	3,902,470,965.14	(105,807,058.32)

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын дансанд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор сургалт болон бусад үйлчилгээний зориулалттай 41,012.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 43,930.9 мянган төгрөгийг зарцуулж, үндсэн хөрөнгийн

шинж чанартай 51,439.2 мянган төгрөгийг ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн;

- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 51,470.8 мянган төгрөгөөр буурсан;

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,442,388.2 мянган төгрөгөөр урсгал зардлыг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Батлагдсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 9,357.0 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 1,433,031.2 мянган төгрөг өөрийн орлогоор 5,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,438,031.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,321,553.0 мянган төгрөг буюу 91.9 хувьтай байгаа нь багаж, техник хэрэгслийн зардал 110,000.0 мянга, ашиглалтын зардал 4,000.0 мянга, ажил олгогчоос төлөх НДШ зардал 2,862.3 мянга, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 488.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан, 129,254.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71802	Ерөнхий боловсролын үйл ажиллагаа хэрэгжүүлэх	1,438,031.2	1,321,553.0	117,478.2	91.9
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,337,375.2	1,220,385.4	116,989.8	91.3
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	100,000.0	99,511.6	488.4	99.5
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшууллын зардал	656.0	656.0	-	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Боловсролын чанарын шинэчлэл төслийн үйл ажиллагаа нь сургалтын үр өгөөжийг сайжруулах, багш бэлтгэх ба багшийн мэргэжил дээшлүүлэх, сургуулийн тэтгэлэгт

хөтөлбөр хэрэгжүүлэх, системийн удирдлага мониторинг гэсэн 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 91.9 хувийн биелэлттэй, 2.8 хувь буюу 239,183.6 мянган төгрөгөөр дутуу байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд багш, сурагч, эцэг эхчүүдэд сэтгэлзүйн зөвлөгөө авах гэрээт ажлын хөлс 15,000.0 мянган төгрөгийг “Сэтгэлзүйн боловсрол олгох төв” төрийн бус байгууллагад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Шинэ эрин лаборатори сургуулийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зорицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шинэ эрин лаборатори сургууль нь 2021 онд нийт 1,930.1 сая төгрөгийн 58 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 168,2 сая төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Батлагдсан төсөвт зардлын дүнг 10-аас доошгүй хувь, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвар усны хэрэглээг 20-иос доошгүй хувиар хэмнэлт гаргаагүй 1,825.8 мянган төгрөг байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, эрх үүрэг ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангаж ажиллах, Албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Батлагдсан төсөвт зардлын дүнг 10-аас доошгүй хувь, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвар усны хэрэглээг 20-иос доошгүй хувиар хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авалтын гэрээний хэрэгжилт Сангийн сайдын 2021 оны тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 51,605.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрүүлснээс 51,437.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 168.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад биелэлт нь 100 хувьтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 5,000.0 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй зөрчилд 1 албан шаардлагын биелэлт 23,936.4 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Албан шаардлага	1	5,000.0	1	5,000.0	-	-	100
Зөвлөмж	3	23,936.4	3	23,936.4	-	-	100
Нийт дүн	4	28,936.4	4	26,585.4	-	-	100

Нягтлан бодох бүртгэл хөтөлт, санхүүгийн тайлагналыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн аккруэл сууриар бүртгэж тайлагнах зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг мөрдөж ажиллах, хуулийн дагуу төсвийг тодотгох хүсэлт гаргаж, хэрэгжүүлэх талаар өгсөн зөвлөмжийн зөрчлийг 3,864.6 мянган төгрөгөөр давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 58,009.8 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 51,437.2 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, хүргүүлж, 4,746.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 1 алдаа, зөрчлийн дүн 4,746.8 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 12,990.4 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 113 нэр төрлийн 51,437.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн;

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 13 нэр төрлийн 4,578.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн;

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл; Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягт: 13.1 дэх " Анхан шатны маягт нь нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөх үндэслэл болно", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг тус тус мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх .

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Шинэ эрин лаборатори сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д / д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Шинэ эрин лаборатори сургууль	АХГ-2022/43/НА-СТА-ТХН	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 113 нэр төрлийн 51,437.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн	Залруулга хийх	1	51,437.2	1	51,437.2								
2	Шинэ эрин лаборатори сургууль	АХГ-2022/43/НА-СТА-ТХН	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 13 нэр төрлийн 4,578.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.	Зөвлөмж өгөх	1	4,578.6								1	4,578.6	
Санхүүгийн тайлангийн нийцлийн асуудлаар																
1	Шинэ эрин лаборатори сургууль	АХГ-2022/43/НА-СТА-ТХН	Нийт 1,930.1 сая төгрөгийн 58 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 168,2 сая төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх	1	168.2								1	168.2	
	Шинэ эрин лаборатори сургууль	АХГ-2022/43/НА-СТА-ТХН	Батлагдсан төсөвт зардлын дүнг 10-аас доошгүй хувь, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвар усны хэрэглээг 20-иос доошгүй хувиар хэмнэлт гаргаагүй	Засгийн газрын 43—р тогтоолыг хэрэгжүүлээгүй	1					1	1,825.8					
Дүн					4	58,009.8	1	51,437.2			1	1,825.8		2	4,746.8	
Нийт дүн					4											



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 196/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/43/НА-СТБ-ТУМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д хийсэн Шинэ эрин сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсөвт зардлын дүнг 10-аас доошгүй хувь, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг 20-иос доошгүй хувиар хэмнэж ажиллаагүй 1,825.8 мянган төгрөг байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1. үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах,

1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинэ эрин лаборатори сургуулийн захирал Б.Амартүвшинд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Т.ХОРОЛСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

\\10.10.20\Bichig_Khureg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-207.Docx

0010800665

